

## **“ICHLINKS төслөөр дамжуулан монголын СББӨ-ийн мэдээллийн санг баяжуулах, цахим контент боловсруулах нь” төслийн хэрэгжилтийн тайлан**

**Төслийн зорилго:** Монголын Соёлын биет бус өвийн мэдээллийн санг бий болгох, видео болон гэрэл зургийн контентыг хөгжүүлэн ichLinks төслөөр дамжуулан Монголын СББӨ-ийг сурталчлах. Ази-Номхон далайн бүс нутагт СББӨ-ийг хамгаалах талаар олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх.

**Хугацаа:** 2020 оны 10 дугаар сар – 2021 оны 11 дүгээр сар.

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Соёлын өвийн үндэсний төв (СӨҮТ)

### **Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл:**

Төслийн гэрээний дагуу СӨҮТ-ийн зүгээс Монголын СББӨ-ийн мэдээлэл болох текст, видео, зургийг шинэчлэх ажилд 4 хүнийг сонгон шалгаруулж ажлуулсан. Үүнд СББӨ хамриуцсан мэргэжилтэн 2 хүн, орчуулагч 1, редактор 1 хүн багтаж байна. 120 өвийн англи хэл дээрх текстийн анхны хувилбарыг 2020 оны 10 дугаар сард ICHCAP-д хүргүүлсэн бөгөөд 2020 оны 11-р сарын 30-ны өдөр мэдээллийг дахин шинэчилсэн болно.

Мөн 2021 оны 3-р сард ichLinks вэб сайтын (ichlinks.com) албан ёсоор нээлтэд зориулан СӨҮТ-ийн захирал Г.Энхбатын мэндчилгээний видео бичлэгийг англи хадмал орчуулгатайгаар хийж, монтаж хийж хүргүүлэв.

2021 оны 3-р сарын 12-нд болох нээлтийн арга хэмжээнд зориулан Соёлын өвийн үндэсний төвийн танилцуулга видеог хүргүүлэн, нээлтэд Дэлхийн өв хариуцсан БМСанч М.Цэцэнбилэг оролцов.

Төслийг хэрэгжүүлэх, СББӨ-ийн мэдээллийн санг хөгжүүлэх, шинэчлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг 2021 оны 6-р сард худалдаж авсан. Үүнд видео болон аудио контентыг засварлах, хадгалах өндөр хүчин чадалтай ширээний компьютер, баримт бичгийн материалтай ажиллах зөөврийн компьютер, принтер, хээрийн судалгаа, студийн билчлэгт дуу бичих микрофон, видео камер тогтворжуулагч зэрэг орно. Тоног төхөөрөмжийг төслийн гэрээний дагуу ашиглаж байна.

Төслийн хүрээнд “хэрлэнгийн барьяа” уртын дууны анхдугаар наадам, Дундговь аймгийн Дэлгэрхангай, Өвөрхангай аймгийн Бүрд, Хужирт, Хархорин сум, Архангай аймгийн Хашаат, Өгийнуур, Эрдэнэбулган, Төв аймгийн Сэргэлэн сумдад баримтжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

Төслийн баг 4-5-р сард хээрийн зураг авалтыг зохион байгуулахаар төлөвлөж байсан боловч COVID-19 цар тахлын улмаас хорио цээрийн дэглэм тогтоосон тул хойшлуулж, 2021 оны 6-9 дүгээр сард зохион байгууллаа.

Төслийн баг 2021 оны 1-р хагасыг дуустал видео болон гэрэл зургийн материал цуглуулж, 6-р сард "Titans Пикчерс" ХХК, видео продакшны студитэй Монголын СББӨ-ийн элементүүдийг багтаасан 30 богино хэмжээний видео контент бүтээх ажлын гэрээ

байгуулсан. Эдгээрт ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалт, яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад Монгол Улсаас бүртгүүлсэн өвүүд орсон болно.

Контентийг

<https://www.ichlinks.com/search/searchL.do?page=9&reSearch=&preText=&searchText=mon-golia&gubun=E> холбоосоор орж үзнэ үү.

Үүнд:

1. Хөхүүрийн айраг хийх уламжлалт арга ухаан, зан заншил (2019),
2. Уул, овоо тахих Монгол зан үйл (2017),
3. Шувуучлахуй (2016),
4. Ингэнд ботго авхуулах зан үйл (2015),
5. Шагайн харваа (2014),
6. Монгол гэр урлах уламжлал (2013),
7. Монгол уран бичлэг (2013),
8. Лимбэний битүү амьсгаа (2011),
9. Монгол Наадам (2010),
10. Монголын уламжлалт Хөөмэй урлаг (2010),
11. Монгол тууль (2009),
12. Монгол Бий Биелгээ(2009),
13. Монгол Цуур (2009),
14. Монгол Морин хуур (2008),
15. Монгол Уртын дуу (2008),
16. Мал сэтэрлэх зан үйл,
17. Уламжлалт цагаан сарын баяр,
18. Монголчуудын уламжлалт нүүдлийн зан үйл,
19. Хөдөлмөр, зан үйлтэй холбоотой уриа дуудлага,
20. Сүү, цагаан идээ бэлтгэх уламжлалт арга,
21. Арьс шир боловсруулах уламжлалт арга,
22. Боодог,
23. "Ёхор" буриад бүжиг, наадаан.

24. Ерөөл,
25. Хүүхдийн даахь үргээх зан үйл,
26. Шимийн архийг нэрэх уламжлалт арга,
27. Уралдааны морь сойх уламжлалт арга,
28. Нум сум хийх уламжлалт арга,
29. Сулхарын гурил боловсруулах арга,
30. Уламжлалт исгэрээний урлаг.

**Өвөрхангай аймгийн Бүрд, Хужирт, Хархорин, Архангай аймгийн Эрдэнэбулган, Их-Тамир сумдад Соёлын биет бус өвийг баримтжуулсан ажлын тайлан.**

“Монголын СББӨ-ийн мэдээллийн сан, цахим контентыг ICHLINKS төслөөр дамжуулан хөгжүүлэх нь” төслийн хүрээнд Өвөрхангай аймгийн Бүрд, Хужирт, Хархорин сум, Архангай аймгийн Хашаат, Өгийнуур, Эрдэнэбулган сумдын нутгаар Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийг дуу, дүрс бичлэгээр баримтжуулах, УНБМСанг баяжуулах зорилгоор 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 7 хоногийн хугацаатай томилолтоор ажиллав.

**Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд:**

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Насанжаргал (Соёлын өвийн үндэсний төвийн Бүртгэл, судалгааны газрын дарга)

Гишүүд:

Ц.Жаргалсайхан (Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын БМСанч)

Т.Оюунбат (Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын БМСанч)

Д.Мөнхбаатар (Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын Дүрс бичлэгийн оператор) нар ажиллав.

Баримтжуулалтын баг Өвөрхангай аймгийн Бүрд, Хужирт, Хархорин сумдад:

- Арьс шир боловсруулах арга технологи /Бүрд/
- Цайны дээж өргөх ёслол
- Монгол дээл исгэх урлал /Бүрд/
- Монгол бөхийн зодог, шуудаг урлал /Бүрд/

- Сийлбэр /Хужирт/
- Хөөмий, Ерөөл, Магтаал /Хархорин/
- Шимийн архи нэрэх арга технологи /Хархорин/
- Шагайн наадгай /Хархорин/
- Монгол Уран бичлэг /Хархорин/

Архангай аймгийн Эрдэнэбулган, Их-Тамир сумдад:

- Хөдөлмөр зан үйлийн холбогдолтой уриа дуудлага буюу Сарлагтай холбоотой уриа дуудлага
- Уулын хярд ассан малыг дүүгүүрийн хүчээр буулгаж авах арга, /Их-Тамир/
- Тарваганы боодог хийх арга технологи /Эрдэнэбулган/
- “Тамирын цагаан” ааруул хийх арга технологи /Эрдэнэбулган сум/-ийг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулж нийт 94,29 GB цахим баримтыг цуглуулж УНБМСанд хүлээлгэн өгөв.

### 2021 оны 09 дүгээр сарын 17 /эхний өдөр – Өвөрхангай Бүрд сум/

Баримтжуулалтын баг Улаанбаатар хотоос 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 10 цагт хөдөлж 16 цагийн орчимд Өвөрхангай аймгийн Бүрд суманд очсон. Биднийг Соёлын төвийн эрхлэгч О. Эрдэнэтуяа болон соёлын төвийн хамт олон тосч авснаар бид ажлын удирдамжаа танилцуулж ажлаа эхлүүлэв.

Соёлын төвийн ажилтнууд биднийг замчлан Сумын төвөөсөө зүүн хойт зүгт 8 км-т байрлах Цагаан чулуут гэдэг газар Донгитын 3 дугаар багийн нутагт дэвгэрт амьдардаг Шагдарын Ганхуяг гэдэг айлын Ууган хүү Г.Батбямбын өвлөн эзэмшсэн сур элдэх арга технологитой танилцаж баримтжуулалтыг хийв. Г. Батбямба ааваасаа сур элдэх, арьс боловсруулах эрдмийг сурсан. Сумын өвлөн уламжлагчийн бүртгэлд 2020 онд бүртгүүлсэн. Батбямба нь 2000 оны 05 дугаар сарын 06-нд Улаанбаатар хотод төрсөн, 20 настай, 8-р ангиа төгсөөд сур элдэх боловсруулах эрдэмд шамдан өдгөө хүртэл хийсээр байна. Ганхуягынх энэ нутгийн угуул иргэн юм. Сур элдэх уламжлалт арга нь дотроо олон янз байдаг. Сур хийх ажиллагаа нь хүнд хүчир, урт удаан хугацаа шаарддаг, улирлын чанартай хэдий боловч, олон жилийн проптипт, туршилтаар нотлогдсон бөгөөд биеийн хөдөлмөрт оюуны хөдөлмөрөө шингээсэн учир эдэлгээний чанар сайтай суран эдлэл боловсруулах боломж өгдөг. Сур хийх



ширийг зүсэх горим үхрийн биеийн хойд хэсгийн арьсыг яралгүй нимгэн цавь орчмоор туламлан зоо нурууны голоос 10-15см зайд аман хүзүүний тус газраас өгзөгний товгорыг дайруулан их биеийг битүү тойруулан зүсэж тус бүр нь 3,8-4,0м урттай 8-9 ширхэг зүсэм шир гаргаж элдээд хооронд нь залгаж бугуйл, аргамж, чөдөр зэргийг хийдэг.

Баримтжуулалт 17 цаг 20 минутаас 19 цаг хүртэл үргэлжилсэн.

### 2021 оны 09 дүгээр сарын 18 /2 дахь өдөр /

Өвөрхангай аймгийн Бүрд сумаас зүүн хойш 18 км-т байрлах “Тохилын нуур” гэдэг газар Мативын Отгонбатынд 09 дүгээр сарын 17-ны өдөр 19 цаг 30 минутад Бүрд сумын Соёлын төвийнхнөөр замчлуулан очсон. Цаг орой болж гэрэл тавих боломжгүй байсан тул Отгонбатынд хоноглон маргааш өглөө нь нар гарч байгаа болон өглөөний цайны дээж өргөж байгаа зураг, зодог шуудаг эсгэх, оёх зэрэг үйл явцыг дүрс бичлэгээр баримтжуулсан.

Гэрийн эзэгтэй Бямбасүрэнгийн Сарантуяа бөхийн зодог шуудаг урладаг. Сумын Бүртгэл мэдээллийн санд бүртгэгдээгүй. 1987 онд төрсөн. 2004 онд Үйлдвэрлэл урлагийн полтехникийн их сургуулийг төгссөн. 2009 оноос зодог, шуудаг урлаж эхэлсэн. Улсын Арслан Ганбаатарын зодог шуудаг урлах цехэд ажиллаж байсан. Тэрвээр Дашзэвэгийн Даваасүрэн гэдэг найзаасаа сурсан. 200 гаруй зодог, шуудаг урласан. Амсарын оёдол нь шаглах оёдол гэж нэрлэдэг. Хөших оёдол нь 3-ыг зэрэгцүүлэн оёхыг хэлдэг. Хөшиг оёдол, шаглаа оёдол, туулай харайлт гэж байдаг. Цөөхөн ширээсийг өргөн харагдуулдаг буюу жижиг оёдолоо нэг нэгээр нь тараах байдалтай оёхыг туулай харайлт оёдол гэж нэрлэдэг. Туулайн харайлтаар чимэглэн өргөн харагдуулдаг оёдолыг залуучууд ихэвчлэн захиалж хийлгэдэг. Дээхэн үед цолноос шалтгаалан ширээс нэмэгддэг. Үхрийн шөрмөсийг бэлдэж оёдог байсан байна. Урьд өмнө 5 ширээстэйг өмсдөг байсан бол одоо олон ширээстэйг өмсдөг болсон байна. Энэ нь харагдах байдал нь гоё сайхан харагддаг болохоор олон ширээстэй хийлгэдэг болсон. Зодогийг Уутан хэлбэртэй, саран хэлбэртэй гэж 2 ангилдаг.

Зодогний ширээс 21-ээс хэтрэхгүй хамгийн багадаа 5 байна. Ширээсийн тоо ахих тусам ширээс хатуу болдог нь барьц авахад төвөгтэй болдог. Бүдүүн





утсаар оёх тусам бат бөх, мөн материалдаа наалдаж өгдөг. Шуудагны дотрыг хөлс шингээдэг даавуун материалаар эсгэж оёдог. Нэг зодог шуудгийг 5-7 хоногийн хугацаанд урладаг.

Бүрд сумын 3 хүнд заасан бөгөөд хотод байдаг найз, нөхөд гээд 10 хүнд заан сургасан. Зодог шуудаг нь 2 эсгүүртэй. Далбааг эсгэж үзүүллээ. Эхлээд хүнээс биеийн хэмжээг авна. Тус хэмжээн дээр оёдол оёх эмжээг нэмж тооцоолж эсгэнэ.

Ажлаа дуусгаад дараагийн айл болох сумын төвөөс зүүн тийшээ 9 км-т байдаг Нарийн гол гэдэг газарт Шагдарын Батбаатарын ирэв. Түүний эхнэр Нямдоржийн Отгонжаргал малчин. 1980 онд Архангай аймгийн Хашаат суманд төрсөн. Ээжээсээ дээл эсгэх болон оёхыг сурсан. Монгол дээл урладаг. 2001 оноос эхэлж гардаж бие даан оёж эхэлсэн. Эсгүүр



гэхээсээ илүү таарсан дээл тавьж эсгэдэг. Дээлийг эхлээд эх бие дараа нь энгэр, дараа нь ханцуй, зах гэсэн дарааллаар эсгэдэг. Нударгыг хамгийн сүүлд нь тавьж эсгэдэг. Эсгэсний дараа хажлагаа нааж бэлдэнэ. Түүний дараа хажлага дээл хоёроо хавсарсны дараа дээлний дотрыг залгаж оёсноор эх бие дуусна. Дараагийн хэсэгт дээлний товч шилбийг оёно. Нэг дээлэнд 7-9 шилбэ ордог гэв.

### 2021 оны 09 дүгээр сарын 19 /3 дахь өдөр – Өвөрхангай, Хужирт сум/

2021 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн 15 цаг 30 минутад Өвөрхангай аймгийн Хужирт суманд хүрч өвлөн уламжлагч Чулуунбат овогтой Батхуягтэй уулзаж зураг авалтынхаа ажлыг эхлэв.

1980 онд Өвөрхангай аймгийн Хужирт суманд төрсөн. Сумандаа технологийн багшаар ажиллаж байсан. Сийлбэрийг ааваасаа өвлөж авсан. Аав МУСГЗ, уран сийлбэрч Г.Доржийн шавь байсан. 2001-2005 онд МУУГЗ Тогтохбаярын шавиар суралцсан. Анх морины сийлбэрээс эхлэж 5 хошуу мал зэрэг янз бүрийн сэдвээр сийлбэр хийсэн. 2008 онд Төрийн ордны хүндэтгэлийн өргөөний



сийлбэрт гар бие оролцсон. Сургуульдаа багшилаад 3 жил болж байна. Цөөнгүй шавь бэлдэж байна. Ихэвчлэн захиалгаар бүтээлээ хийдэг. Багажаас дурьдвал хутга, цүүц нь багаас их гар хүртэл хэмжээтэй байна. Морины уяаны сойлго, морины шүтээн зэрэгт захиалга голчлон ирдэг. Шашин талд Гүнгэрвээ, сэнтий, ямпай, чулуун хөөрөг зэргийг хийж байна. 1999 оноос хойш өдгөө хүртэл морь гэхэд 400 орчим сийлбэр хийсэн байх. Нарс мод зөөлөн хэрнээ ширхэг нарийн болохоор ямар ч бүтээл хийхэд тохиромжтой.

2021 оны 09 дүгээр сарын 20. /4 дахь өдөр – Өвөрхангай, Хархорин сум/

2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Дэлхийн өв - Орхоны хөндийн хамгаалалталтын захиргааны ажилтан Ханджавтай холбогдон ажлын удирдамжаа танилцуулж баримтжуулалт хийх өвлөн уламжлагчийн талаар ярилцан ажлаа төлөвлөв. Хархорины уугуул иргэн өвлөн уламжлагч ерөөлч, хөөмийч Арслангийн



Эрдэнэхүүгийн очиж зураг авалтаа эхлүүлэв.

А.Эрдэнэхүү 1957 онд Өвөрхангай аймгийн Хархорин суманд төрсөн. Хөдөө мал маллаж яваад анх Монголын радиогоор алдарт хөөмийч Чимэддорж гуай хөөмийлж байхыг сонсож байсан.

Хувиараа ерөөл магтаалаа сурталчилж явна. Хүүхдийн үсний найр болон шинэ гэрийн найр хурим болон соёл, урлагийн арга хэмжээнд оролцож явсан. 1993 онд ХБНГУ-д, алдарт ерөөлч Чимэддоржтой ерөөл, магтаал, хөөмийн урлагийг сурталчилах соёл, урлагийн арга хэмжээнд олон жил оролцсон. Анх Ерөөл магтаалыг манай нутгийн ерөөлч, магтаалч Довдон гуайг даган дууриах маягаар сурсан. Голдуу шинэ байшин болон өрх гэрийн гал голомтоо тусгаарлаж байгаа залуу хосуудын шинэ гэрийн найранд уригдаж ерөөлөө дууддаг. Өөрөө голдуу ерөөл зохиож бичиж байгаад ерөөдөг. Шууд цэцэлж байгаагүй. Ерөөлөөсөө Монголын радиогийн алтан фондод бичүүлсэн. Өөрийн зохиосон ерөөлийг нэгтгэж ном хэвлүүлсэн. Шавь гээд дурьдаад байх юмгүй, ганц нэг зориод ирсэн сонирхогчдод зааж сургадаг юм. А.Эрдэнэхүү дараах 4 аргаар хөөмэйлж байна. Үүнд: Хамар нармайн хэсгээр ба цохилттой бөгөөд хэл, тагнай 2 давхар хөөмийлэх, цээжний хөөмий гэх зэргээр хөөмийлж байна.

Тус өдөр мөн сумын иргэн Сүрэнгийн Дашдаваагийн очиж Уран бичлэг /калиграфи/-ийн өвийг өвлөсөн өвлөн уламжлагчийнд зураг авалт хийж 17 цаг 45 цагт дууссан.

Шагайн наадаан.

Хархорин сумын төвд амьдардаг Чимэддоржийн Баттулгын шагайн наадааны зураг болон дүрс бичлэгийг хийлээ. Дүрс бичлэгт Хархорин сумын Улсын тэргүүний Орхон сургуулийн суралцагчид оролцлоо. Үүнд: 10 настай, хүү Түмэнжаргалын Төгсбаяр 10 настай Баттулгын Түвшинсанаа, 8 настай, охин 3-р ангийн сурагч Болдбаатарын Уранчимэг, 8 настай 3-р ангийн сурагч, охин Дашдаваагийн Болор, 5 настай хүү Баттулгын Галбадрах нарын зэрэг сурагчид оролцов. Дашдаваагийн Болор охин “Дөрвөн бэрх” шүлэг уншив. Баримтжуулалт 18 цаг 30 минутад дуусав.



2021 оны 09 дүгээр сарын 21, 22. /5 дахь өдөр – Өвөрхангай, Хархорин, Архангай, Эрдэнэбулган сум/

2021 оны 09 дүгээр сарын 21 –ний өдрийн 13 цагт Хархорин сумаас хойшоо 5 км-т байрладаг Нарийн хүр багийн “Уугант” гэдэг газар 13 цагт Цэнд-Аюушийн Гүндцамбынд ирж архи нэрэх арга технологийг баримтжуулах зураг авалтаа эхлүүлэв. Цэнд-Аюушийн Гүндцамбын эхнэр тогоо нэрэх аргыг ээжээсээ сурсан.

Монголчуудын өргөн дэлгэр хэрэглэж ирсэн ундаа бол цагаагаар нэрсэн архи юм. Үүнийг монгол архи, нэрмэл архи, шимийн архи, сүүний архи гэх мэтээр нэрлэх ба бэлтгэх явцыг “тогоо нэрэх” хэмээнэ. Тогоо нэрэхдээ бэлтгэсэн цагаагаа, эсвэл таргаа тогоонд бялхтал хийж, дээр нь дээшээ шувтан хоёр тохой өндөр бүрхээр суулгаж, түүний амсар дээр жалавч буюу жижиг тогоо тавина. Ингээд галдаа шар тос өргөн , галаа түлж цагаа буцлахад спирт ууршин дэгдэж хүйтэн ус бүхий жалавчны ёроолд хөрөөд дусал болон доош унахдаа бүрхээрийн дунд хавьд байрлах тосгуурт хураагдан тусгай цоргоор гадагш гоожиж, тоссон саванд архи хуримтлагдана. Жалавч Бүрхээр хоёрыг гадагшаа уур алдахгүйн тулд даавуугаар ороож хэсэг хугацааны дараа зөөлөн галаар өрдөнө. Анх гоожсон архийг “сувс” гэх ба энэ нь хамгийн муу чанартай архинд тооцогдоно. Сувсаа дахин





нэрвэл архи болох бөгөөд үүнийг “арз”, арзаа дахин нэрвэл “хорз”, хорзоо нэрээд “шарз”, шарзаа нэрээд “борз” болно. Ийнхүү хэдий олон дахин нэрэх тусам архи нь төдий чинээ хатуу гардаг. Харин жалавч буюу бүрхээрийн дээр байх жалавчны ус 30 орчим хэм халахад хүйтэн усаар сольж дүүргэнэ. Ингэж нэг тогоо нэрэхэд 3-4 удаа ус сольдог. Усыг олон солих тусам архины чанар муудах тул 1-2 удаа соливол сайн.

Ааруул хийх арга технологи: 2021 оны 09 дүгээр 22-ны өдөр Сумын төвөөс зүүн тийш 1 км-т Улаан толгой гэдэг газар нутагладаг Чойлжилсүрэнгийн Цогзолын Цагаан идээ боловсруулах арга технологийг

баримтжуулахаар 12 цаг 20 минутад ажлаа эхлүүлэв. Сүүгээ гажилгаад гашилсан сүүгээ ээдүүлнэ. Ээдсэн сүүгээ тогоонд халаан сахар хийн хутгасны дараа хэлбэрт оруулахын тулд модон хэвэнд хийж 2-3 цаг амраана. Түүхий дараа хэвнээс гарган тавьж түүнийгээ утсаар том, жижиг хэсэг болгон хэсэгчилж ааруул хэлбэрт оруулж хатаана. Энэхүү “Тамирын цагаан ааруул” хийх арга технологийг тус сумын даргаар олон жил ажиллаж алдаршсан, Хөдөлмөрийн баатар Ц.Минжүүр гуай санаачилсан бөгөөд одоо энэ аргаар хавар цөөн малчид ааруул хийдэг болсон.



2021 оны 09 дүгээр сарын 23. /7 дахь өдөр – АР, Их-Тамир сум/

Боодог хийх арга технологи

2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр буюу Улаан толгой гэдэг газраас Их-Тамир суманд 12 цагт ирж тус сумын Соёлын төвийн бүжгийн багш Даваадоржийн Галбадрахын зураг авалтаа эхлүүлсэн. Тарвагыг зориулалтын өмсгөл хувцас өмсөн агнадаг. Боодог хийхэд нарийн ширхэгтэй мөлгөр (голын) чулууг (тарваганд 10-15 орчим, ямаанд бол (түүнээс том чулуунууд)) сонгон авч задгай галд хийж улайсгана.



Тарвагыг боохдоо эхлээд эрүүнээс нь сэнжлэн юмнаас дүүжлээд арьсыг нь махтай нь туламлан өвчинө. Ийнхүү өвчих явцдаа гэдэс дотрыг нь авч ясыг эвдэж авна. Улайдаж бэлэн болсон чулуугаа хойд хоёр хөлнөөс нь эхлэн чулуу, мах хоёроо ээлжлэн хийж, давс, сонгино, хөмүүл зэргээр амтлан, бага зэрэг сэгсрэн чихсээр тулмаа дүүргэж амыг нь адууны сүүл буюу нарийн утсаар бооно. Боодгоо гадна талаас нь задгай гал дээр тал талаас нь эргүүлж, жигд шарж үсийг нь хуйхлан зумлаж хусч цэвэрлэнэ. 15-20 минутын дараа боодог болно. Боодогонд ямар ч ус шүүс хийлгүй өөрийнх нь шүүсээр болгодог тул онцгой сайхан амттай байдаг. Хэт их хүчтэй шарвал арьс язарч шатдаг тул жигд зөөлөн галаар эргүүлж тойруулан шарах ба сайн хийсэн боодогны хуйх тос даасан зөөлөн шаргал, мах нь жигд болсон байдаг.

Сарлагтай холбоотой уриа дуудлага /Их-Тамир сум/

2021 оны 09 дүгээр 23-ны өдрийн 12 цагт Архангай аймгт ирж Музейн даргатай уулзаж удирдамжаа танилцуулан сумдад ажиллах чиглэлээ гаргав. Их-тамир сумруу өдрийн 15 цагт хөдөлсөн. Аймгийн төвөөс баруун хойш 23 км-т орших ИХ-тамир сумын Сумын соёлын төвийн эрхлэгч болон ОНСТ-ын ажилтан нартай уулзаж ажлын удирдамжаа танилцуулан улмаар зураг авах тухай ярилцаж өвлөн уламжлагчаа сонгоод



маргааш өглөө 10 цагт сумын төвөөс хойш зүгт 8 км-т нутагладаг малчин Б. Болдрагчаагийн дунд очиж сарлаг хураах, уулын хярд ассан малыг дүүгүүрийн хүчээр буулгаж авах арга, дүүгүүрийн зураг авалтаа эхлүүлсэн. Сарлаг дүүгүүрийн сум шиг чулууны исгэрэх чимээнээс маш их айдаг. Энэ чимээ л сарлагийг уулнаас буулгах шидтэй гэнэ. Хэчнээн ороолгож, шилбүүрдээд ч нэмэргүй. Дүүгүүрдэж мэдэхгүй, чадахгүй нэгнийг дошсон сарлагийн эрэлд явуулвал дэмий л явдлын гарз болж, уур уцаараа барахын нэмэр. Даанч хүний уурлах, хашгирах түүнд хамаагүй гэж нутгийн уугуул ярилцдаг юм байна. Малчин Б. Болдрагчаа ярихдаа дүүгүүрдэж байгаад үнээнийхээ нүдийг онож гэмтээснээс хойш тэр болгон дүүгүүрдэж буулгахаа болиод байна гэж хуучлав. Бид тэр өдрөө баримтжуулалтын ажлаа дуусган 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр Улаанбаатар хотын зүг хөдлөв.

### **Дундговь аймгийн Эрдэнэдалай суманд Соёлын биет бус өвийг баримтжуулсан ажлын тайлан.**

“Монголын СББӨ-ийн мэдээллийн сан, цахим контентыг ICHLINKS төслөөр дамжуулан хөгжүүлэх нь” төслийн хүрээнд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийг дуу, дүрс бичлэгээр баримтжуулах, УНБМСанг баяжуулах зорилгоор 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөс 4 хоногийн хугацаатай томилолтоор ажиллав.

#### **Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд:**

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Насанжаргал (Соёлын өвийн үндэсний төвийн Бүртгэл,  
судалгааны газрын дарга)

Гишүүд:

Т.Сүхбаатар (Сэргээн засварлагч, судлаач)

Т.Амар (Найруулагч)

Б.Хангарьд (Зураглаач)

Э.Нармандах (Зураглаач)

П.Есөнбаатар (Жолооч) нар ажиллав.

Баримтжуулалтын баг Дундговь аймгийн Дэлгэрхангай суманд:

- Гүү барих



- Унага тамгалах
- Мал сэтэрлэх зан үйл
- Чөдөр зангидах арга технологийг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулж нийт 83,3 GB цахим баримтыг цуглуулж УНБМСанд хүлээлгэн өгөв.

### 2021 оны 08 дугаар сарын 18-22 өдөр

Баримтжуулалтын баг 08 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотоос 470 орчим км-т орших Дундговь аймгийн Дэлгэрхангай сумруу 10 цагт хөдөлж оройн 23-т сумын төвд ирэв. 08 дугаар сарын 19-ны өдөр буюу маргааш өглөөний 06 цагт сумын төвөөс хойт зүгт 9


орчим км-т 4-р багийн малчин Т.Үнэнтөгөсийнд очиж унага барих, тамгалахтай холбоотой гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх талаар ярилцаж ажлаа төлөвлөв. 09:00 цагт



адуу хурааж дроноор агаарын зураг, бичлэгийг хийж эхлэв. Үргэлжлээд ууган унага барих, (үрс гаргах) зан үйлийг баримтжуулж оройн 18 цаг хүртэл баримтжуулалтын ажил үргэлжлэв.

2021 оны 08 дугаар сарын 20, 21-ний өдөр сумын төвөөс баруун урд зүгт орших 2-р багийн малчин Ж.Алтангоогийнд очиж мал сэтэрлэх, унага тамгалах, унага уях

(үрс гаргах) зан үйл, бэсрэг баяр тэмдэглэж байгаа талаар баримтжуулалтыг хийж, 4-р багийн малчин Б.Баярсайханаар морины чөдөр зангидаж буй үйл явцыг баримтжуулав. Баримтжуулалтын баг төлөвлөсөн хугацаанд гэрэл



зураг, дүрс бичлэгийг хийж дуусаад 08 дугаар сарын 22-ны өдрийн өглөө улаанбаатар хотруу буцсан.

**Төв аймгийн Сэргэлэн суманд Соёлын биет бус өвийг баримтжуулсан ажлын тайлан.**

“Монголын СББӨ-ийн мэдээллийн сан, цахим контентыг ICHLINKS төслөөр дамжуулан хөгжүүлэх нь” төслийн хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг (Дов хайрхан)-т Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийг дуу, дүрс бичлэгээр баримтжуулах, УНБМСанг баяжуулах зорилгоор 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдрөөс 3 хоногийн хугацаатай томилолтоор ажиллав.

**Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд:**

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Насанжаргал (Соёлын өвийн үндэсний төвийн Бүртгэл, судалгааны газрын дарга)

Гишүүд:

А.Мөнгөнцоож (Судлаач)

С.Баасандорж (Зураглаач)

Д.Мөнхбаатар (Зураглаач)

С.Сайнзолбоо (Жолооч) нар ажиллав.

Баримтжуулалтын баг Төв аймгийн Сэргэлэн суманд:

- Улаан идээ боловсруулах, мал төхөөрөх уламжлалт арга /Үхэр, Адуу/
- Исгэрээ
- Хөдөлмөр зан үйлийн холбогдолтой уриа дуудлага, тойглох /хонь, хурга/
- Уламжлалт хоол боловсруулах мэдлэг ухаан /цагаан шавиа, китай/
- Цагаан идээ боловсруулах арга /сүү хөөрүүлэх, өрөм загсаах/-ыг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулж 74,55 GB цахим баримтыг УНБМСанд хүлээлгэн өгөв.

2021 оны 11 дүгээр сарын 24-27 өдөр



Баримтжуулалтын баг 11 дүгээр сарын 24-ны өдөр Улаанбаатар хотоос 10:00 цагт хөдөлж өдрийн 15:00 цагт Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг “Довхайрхан”-ы Мурий гэх газарт өвөлжиж буй малчин А.Батболдын ирсэн. Сумын төвөөс баруун урд 80 орчим км-т дэл гэх газар өвөлжиж буй 2 -р багийн малчин Ч.Алтантүлхүүрийнд очиж Улаан идээ боловсруулах, мал төхөөрөх уламжлалт арга /Үхэр, Адуу/, Исгэрээ, Уламжлалт хоол боловсруулах мэдлэг ухаан /цагаан шавиа, китай/, Цагаан идээ боловсруулах арга, сүү хөөрүүлэх, өрөм загсаах зэрэг холбоотой гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх талаар ярилцаж ажлаа төлөвлөв.



Маргааш буюу 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 09:00 цагт Хөдөлмөр зан үйлийн холбогдолтой уриа дуудлагын төрөл болох хонь тойглож буй дүрс бичлэгийг хийж эхлэв. Үргэлжлээд улаан идээ боловсруулах буюу Үхэр, Адуу төхөөрж буй өвлийн хоол хүнсээ зэхэж байгаа талаар баримтжуулж оройн 17 цагт нар жаргаж баримтжуулалтын ажил дуусав.

2021 оны 11 дүгээр сарын 26-ний өдөр Цагаан идээ боловсруулах арга буюу сүү хөөрүүлэх, өрөм загсаах, худаг дээр морь услах, исгэрээ, цайны дээж өргөх, хурганы арьс элдэх, шүүлэх зэрэг үйл явцыг баримтжуулав. Баримтжуулалтын баг төлөвлөсөн хугацаанд гэрэл зураг, дүрс бичлэгийг хийж дуусаад 11 дүгээр сарын 27-ны өдрийн өглөө улаанбаатар хотруу буцав.

## **Дүгнэлт**

2020 оны 2-р сараас 2021 оны 6-р сар хүртэлх хугацаанд COVID-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас Монгол Улсын засгийн газраас цагаан сар (уламжлалт цагаан сар), уламжлалт баяр наадам, соёл урлагийн арга хэмжээ зэрэг бүх томоохон арга хэмжээг цуцалсан тул ажлын төлөвлөгөөний зарим нэг хэсэгт өөрчлөлт орсон болно. 2020 оны 11-р сараас 2021 оны 5-р сар хүртэлх хугацаанд улс доторх зорчих хөл хөдөлгөөнд хатуу хязгаарлалт тавьж, хатуу хорио цээрийн дэглэм тогтоосны улмаас төслийн багийг онлайнаар ажиллуулахаас аргагүйд хүрч, төслийн үйл ажиллагааг төлөвлөсний дагуу хэрэгжүүлэхэд хүндрэл учруулсан. Тиймээс төлөвлөсөн ажлуудын ихэнхийг 2021 оны

хоёрдугаар улирал хүртэл хойшлуулсан. Гэвч төслийн багийнхан Соёлын өвийн үндэсний төвийн мэдээллийн сангаас шаардлагатай мэдээлэл, гэрэл зураг, дүрс бичлэгийг цуглуулж, IchLinks мэдээллийн санд зориулан засварлаж, контентийг хийж гүйцэтгэсэн. Мөн тус багийнхан төсөлд шаардлагатай тоног төхөөрөмжийг интернет, онлайн үйлчилгээг ашиглан худалдан авсан.

СӨҮТ нь “Titans Films” видео продакшны студитэй ажлын гэрээ байгуулж, ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний биет бус соёлын өвийн төлөөллийн жагсаалтад Монгол Улсаас бүртгүүлсэн 15, СББӨ-ийн тухай нийт 30 богино хэмжээний видео контент бэлтгэж, ICHCAP болон ichLinks-ийн нарийн бичгийн дарга нарын газарт амжилттай илгээлээ. Мөн 2021 оны 08 дугаар сарын 27, 28, 29-ний өдрүүдэд Хэнтий аймгийн Сэрвэн хаалганд ардын урлагийн тоглолт, биет бус соёлын өв, соёл урлагийг сурталчлах зорилгоор “Хэрлэнгийн бариа” орон нутгийн уртын дууны наадмыг амжилттай зохион байгууллаа. Сэрвэн хаалганы түүхэн дурсгалт газар болж, олон нийтэд таниулан сурталчлахад хувь нэмэр оруулсан. Тус наадамд Монгол улсын зүүн 4 аймгийн СББӨ өвлөн уламжлагч нар оролцов. Арга хэмжээний үеэр баримтжуулсан видео болон гэрэл зургийн материалыг ichlinks.com вэб сайтын контент бэлтгэхэд ашигласан болно.

Тайлан бичсэн:  Ж.Насанжаргал (Соёлын өвийн  
бүртгэл, судалгааны газрын дарга)

Хянасан:  Д.Нарантуяа (Захиргаа, удирдлагын газрын  
дарга)

## Ichlinks.com-д илгээсэн 120 Соёлын биет бус өвийн жагсаалт:

Элементийн дугаар .	Зургийн тайлбар	Зураг авсан он	Зохиогчийн эрх	Эрхийг хүлээлгэн өгөх зөвшөөрөл
1-1	Туульч А.Балдандорж	2013	NCCH	
1-2	Туульч Б.Уртнасан	1996	NCCH	.
1-3		2013	NCCH	
1-4	Туульч Э.Мэндбаяр	2018	NCCH	
1-5	Тархалтын зураг	2018	NCCH	
2-1	Цуурч Паарай /өвөө/	1996	NCCH	
2-2	Цуурч П.Буяндэлгэр /хүү/	2012	NCCH	
2-3	Цуурч Б.Наранбат /ач/	2018	NCCH	
2-4	Тархалтын зураг		NCCH	
3-1	Биелээч Г.Лхавга	2012	NCCH	
3-2	Бий биелгээ	2011	NCCH	
3-3	Биелээч хүүхдүүд	2018	NCCH	
3.4	Тархалтын зураг			
4-1	Уртын дуучид	2006	NCCH	
4-2	Уртын дуучин Ш.Дулмаа	2011	NCCH	
5-1	Хөөмэйчид	2009	NCCH	
5-2	Хөөмэйч Б.Чинбат	2018	NCCH	
6.1	Морин хуур	2012	NCCH	
6.2	999 торин хуурчын тоглолт, Чингисийн талбай	2013	NCCH	
6.3	Морин хуурч	2015		
7.1	Хүүхдээ бүүвээлж буй ээж	2011		
7.2	Бүүвэйн дуу дуулж буй эх	2011		
8.1	Дархад ардын дуучин Д.Магнайцэцэн	2018		
11.1	Дэмбээ	2016		
11.2	Дэмбээдэх	2018		
12.1	Хүүхдийг шөлөөр угааж байгаа нь	2010		
13.1	Хүүхдийн үс авч байгаа нь	2018		
15.1	Гэр барих үйл явц	2010		

15.2	Гэрийн мод	2010		
15.3	Шинэ гэр барих явц	2013		
16.1	Адуу хөнгөлж буй зураг	2010		
16.2	Хонь хөнгөлж буй зураг	2010		
18.1	Унага тавихын өмнө	2012		
18.2	Унага	2012		
19.1	Унага тамгалж байгаа нь	2012		
20.1	Мал сэтэрлэх зан үйл	2010		
22.1	Нэрмэл нэрэх үйл явц	2018		
22.2	Хөхүүр, сүн, хул	2014		
23.1	Шагайн тойром	2010		
23.2	Цурхай, хасаа	2010		
23.3	Харваачид	2010		
24.1	Шагайгаар наадаж буй хүүхдүүд	2010		
25.1	Цагаан сараар хөөрөглөж байгаа хуухдүүд	2010		
26.1	Бүргэдчин	2011		
26.2	Бүргэдийн баяр	2013		
27.1	Бөөгийн үзүүлбэр	2018		
27.2	Бөөгийн зан үйл	2014		
28.1	Нүүдэллэж байгаа нь	2018		
28.2	Тэмээнд гэр ачиж байгаа нь	2018		
29.1	Харваж буй байдал			
29.2	Нум, сум			
30.1	Тэмээний уралдаан	2010		
30.2	Тэмээчид	2010		
32.1	Буга дуудаж байгаа нь	2009		
32.2	Буга дуудаж байгаа үзүүлбэр	2018		
33.1	Маарамбын эм, хэрэглэл	2012		
33.2	Эмийн ургамал боловсруулах	2018		
34.1	Хатгах үйл явц	2017		
34.2	Ханах багж	2017		
36.1	Байгаль шинжиж байгаа өвгөн	2010		
36.2	Хаврын тэнгэр	2012		
39.1	Ааруул, эзгий, өрөм	2017		NCCH

39.2	Дэлгэцтэй ааруул, хатааж буй	2017		
39.3	Тогоотой өрөм	2017		
39.4	Хувин /модон/	2015		
40.1	Ноос савж байгаа нь	2018		
40.2	Эсгий хийж байгаа нь	2010		
41.1	Талхи /уламжлалт арьс илдэх арга/	2017		
41.2	Сур илдэж байгаа нь	2017		
41.3	Гар талхи	2011		
41.4	Арьс ширэн эдлэл хэрэглэл	2011		
42.1	Угийн бичиг	2012		
43.1	Уралдаж буй морьд	2011		
43.2	Морь хөлөргөж байгаа нь			
44.1	Монгол хувцас	2010		
45.1	Унь эрээлж байгаа нь	2010		
45.2	Тоон хийж байгаа урлаач	2016		
46.1	Ланз хээ	2010		
46.2	Сүйх хээ	2010		
47.1				
47.2	Эсгий ширж байгаа нь	2018		
48.1	Гутал урлаачид	2013		
48.2	Монгол гутал	2011		
49.2	Зодог, шуудаг	2011	<i>NCCH</i>	
50.1	Урлаач Ж.Сүхбаатар	2010		
50.2	Урлаач Ж.Сүхбаатар шавийн хамт	2010		
51.1	Уллах үйл явц	2010		
51.2	Урлаач С.Алтангэрэлийн Их гарын мөнгөн аяга	2011		
51.3	Аяганууд	2011		
52.1	Монгол эмээл	2017		
53.1	“Буурны ноцолдоон” модон сийлбэр	2011		
53.2	Буга модон сийлбэр	2011		
54.1	Зүү ороосон даалин	2011		
54.2	Монгол гутлын хараа	2011		
56.1	Монголын нэг өдөр зураг	2010		
57.1	Очирваань бурханы зээгт наамал	2010		



57.2	Улаанжамсран бурханы зээгт наамал	2012		
58.1	Жамсран бурханы шуумал	2010		
58.1	Жамсран бурханы шүрэн баг	2010		
59.1	Хуучир	2012		
59.2	Луун толгоотой морин хуур	2012		
60.1	Үхэр тэрэг	2018		
60.2	Үхэр тэрэгний дугуй	2012		
61.1	Цахиур буу	2011		
62.1	Уран нугараач	2010		
62.2	Уран нугараачид	2010		
64.1	Лимбэч Ө.Батжаргал	2009		
64.2	Лимбэчид	2008		
65.1	Уран бичлэг бичиж байгаа нь	2013		
65.2	Уран бичээч	2018		
67.1	Монгол цамын бүжиг	2010		
67.2	Цамын бүжиг	2010		
68.1	Онъсон тоглоом	2010		
68.2	Онъсон тоглоомууд	2010		
70.1	Модон бар	2012		
71.1	Ган сийлбэртэй Хэт хутга, алт шармалтай	2012		
71.2	Лянганы багж, ган сийлбэр	2012		
72.1	Овоо	2012		
72.2				
73.1	Хөөсөлж байгаа нь	2013		
73.2	Ингэ, ботго 2	2013		
74.1	Ямаанд хурга авхуулж байгаа нь	2010		
75.1	Алаг мэлхий	2011		
76.1	Бөгж нийлүүлэх тоглоом	2010		
76.2	Гогцоо	2010		
77.1	Хорол	2012		
78.1	Зоосон ширээ	2011		
78.2	Зоос	2011		
79.1	Эрэгтэй малгай	2018		

79.2	Эмэгтэй тоорцог малгай	2010		
80.1	Дархан А.Чойжилсүрэнгийн урласан мөнгөн тоногтой эрэгтэй хүний бүс	2011	<i>NCCH</i>	
80.2	Эмэгтэй мөнгөн бүс	2011	<i>NCCH</i>	
81.1	Утас, ээрүүл, дээс	2011		
81.2	Томсон дээс	2011		
82.1	Хэл хуур тоглож байгаа нь	2018		
82.2	Төмөр хуур	2011		
82.3	Хулсан хуур	2011		
83.1	Эхнэр дээл	2012		
83.2	Дээл урлал	2018		
84.1	Цай чанах	2018		
84.2	Тогоотой цай	2018		
86.1	Наадмын нээлт	2013		
86.2	Барилдаж буй бөхчүүд	2016		
86.3	Сур харваа	2013		
87.1	Бөхчүүд	2010		
88.1				
89.1	Нум сум	2018		
89.2	Хасаа	2018		
89.3	Бай, сум	2018		
90.1	Тойрог бүхий бичээс	2010		
90.2	Цогтын хадны бичээс	2010		
98.1	Ерөөлч Ч.Батбаатар	2018		
99.1	Хошин яриа	2018		
102.1	Дом шившиж байгаа нь	2010		
102.2	Давсаар дом хийж байгаа нь	2010		
103.1	Айтыс	2011		
104.1	Буриад нум сум	2011		
105.1	Тоглогчид	2018	<i>NCCH</i>	
105.2	100 цааст хөзөр	2018	<i>NCCH</i>	
106.1	Тоглогчид	2015	<i>NCCH</i>	
106.2	Өргө /Хушга/	2015	<i>NCCH</i>	
107.1	Тамганы дардсууд	2012		
107.2	Хас тамга	2011		

108.1	Гүүний үрс гаргаж байгаа үзүүлбэр	2018		
108.2	Гүү сааж байгаа нь	2013		
109.1	Модон шатар	2011		
110.1	Бор эзгий	2011		
111.1	Сүүн хурууд	2017		
112.1	Шаант	2018		
113.1	Дархан	2010		
113.2	Хэт хутга	2011		
114.1	Хонь хяргаж байгаа нь	2010		
115.1	Шавар зуух	2018	<i>NCCH</i>	
116.1	Бөөгийн галын тахилга	2014		
117.1	Эсгий ширэх үйл явц	2017	<i>NCCH</i>	
117.2	Эсгий ширмэл	2011	<i>NCCH</i>	
117.3	Хүннүгийн үеийн эсгий ширмэл	2012		
118.1	Уран зангилаа	2012	<i>NCCH</i>	
118.2	Уран зангилаан оройтой малгай	2012	<i>NCCH</i>	
119.1	Ясан сийлбэрүүд	2011		
119.2	Далны ясан сийлбэр	2011	<i>NCCH</i>	
120.1	Шагай тоглож буй залуус	2012	<i>NCCH</i>	
120.2	Шагайн шүүрэх тоглоом	2012	<i>NCCH</i>	

-oOo-